

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ХЯНАЛТАД АВСАН ТОГТООЛ, ТУШААЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

2026 оны 06 дугаар сарын 25

Д/д	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ /%/	Тайлбар
1	2	3	4	5	6
1.Монгол улсын Засгийн газрын тогтоол					
1		2025.12.24 № 226 Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын дагуу газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус газрын байцаагч, ажилтнуудын цалинг шинэчлэн тогтоож, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцон олгож эхэлсэн.		
2		2025.12.31 № 242 Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 242 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 80,000 (наян мянга) төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 769,000 (долоон зуун жаран есөн мянга) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 652,400 (зургаан зуун тавин хоёр мянга дөрвөн зуу) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон. Тус дүүргээс тэтгэвэр авч байгаа нийт 35689 тэтгэвэр авагч нарт тэтгэврийн нэмэгдэлийг нь тухай бүрт нь бодож, цаг хугацаанд нь ямар нэгэн зөрчил дутагдалгүй олгосон байна. Тэтгэвэр авагч иргэдийн тэтгэврийн хэмжээ нэмэгдсэнээр тус дүүргийн иргэдийн дундаж тэтгэвэр 1,082,221 (нэг сая наян хоёр мянга хоёр зуун хорин нэг) төгрөг болж нэмэгдсэн.		

3		2026.01.21 № 22 Ажил, амралтын цагийг зохицуулах тухай	Монгол үндэсний уламжлалт баяр-Цагаан сарын битүүний өдрөөр иргэдийн ажил, амралтыг зохицуулах зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 17-ны Мягмар гаригийн ажлын өдрийг 2026 оны 02 дугаар сарын 28-ны Бямба гаригийн амралтын өдөрт шилжүүлсэн Монгол Улсын засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 22 дугаар “Ажил амралтын цагийг зохицуулах тухай” тогтоолын дагуу газрын байцаагч, ажилтнуудыг тухайн өдөр бүрэн амрааж, 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Бямба гаригт бүрэн ажиллуулж, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан. Цагаан сарын баяр амралтын өдрүүдэд буюу 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд байгууллагын хэмжээнд ажилласан хариуцлагатай жижүүрийн талаарх танилцуулгыг 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 110 дугаартай албан бичгээр Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын даргын нэр дээр хүргүүлсэн.		
4		2026.04.08 № 115 Салбарын хяналт шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Салбарын хяналт шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 115 дугаар тогтоолоор эрүүл мэнд болон байгаль орчны салбараас бусад салбарын 2026 оны төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг цуцлахыг үүрэг болгосон. НДЕГ-ын даргын 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 07/1268 тоот "Шийдвэр хүргүүлэх тухай" албан бичгээр НДЕГ-ын даргын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталсан 02 дугаар "Аж ахуй нэгж байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж"-д заасан хяналт шалгалтыг түдгэлзүүлэн зогсоох тухай шийдвэр ирүүлсэн. Албан бичгийн дагуу тус газраас 2026 онд хийх гадаад хяналт шалгалтын ажлыг зогсоосон.		
Хэсгийн дундаж хувь:					
2.Монгол улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
1		2026.05.06 № 17 дугаар хуралдаан “2025 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар”	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна. Тус газар нь иргэд, даатгуулагч, аж ахуй нэгж, байгууллагаас 2026 оны эхний хагас жилийн байдлаар 297 өргөдөл, гомдлыг хүлээн авснаас 284-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. Шийдвэрлэлийн		

			түвшинд байгаа 13 өргөдөл байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй. Мөн 6 хүсэлт ирснийг холбогдох газруудад хүргүүлсэн. Нийт бичгээр 291, Засгийн газрын 11-11 төвөөс 6 өргөдөл ирсэн байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацааны индекс 0,96 байна. Өргөдөл гомдлыг агуулгаар нь авч үзэхэд тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой 45, сайн дурын даатгалтай холбоотой 8, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой-109, шилжүүлэг залруулгатай холбоотой- 83, ажилгүйдлийн даатгалтай холбоотой-5, бусад 47 байна. НДЕГ болон бусад дээд шатны байгууллагуудаас ABLE программаар ирсэн 574 албан бичгийг хэлтсүүдэд хүргүүлж, албан хаагчдад танилцуулан тайлан мэдээ, судалгааг холбогдох газруудад хүргүүлж ажилласан.		
3. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын албан бичиг					
1		2026.04.14 ХЭГ/1205 Тогтоол хүргүүлэх тухай	“Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 119 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргын 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн ХЭГ/1205 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Тогтоолын 3 дугаар зүйлийг хэрэгжүүлэхдээ 2026 оны эхний хагас жилийн байдлаар албан үүргээ гүйцэтгэж буй төрийн албан хаагчийг орон тооны цомхотголд оруулж, орон тоог цөөлсөн тохиолдол байхгүй байна. Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 119 дүгээр тогтоол, тус газрын хөдөлмөрийн дотоод журам, дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай А/17 дугаар тушаалыг үндэслэн газрын ажилтан, алба хаагчдын ажлын цагт уян хатан зохицуулалт хийж, ажил эхлэх цагийг 07:00-08.30, дуусах цагийг 16:00-17:30 байхаар зохицуулж, үдийн цайны завсарлага 11:00-12:00 цагийн хооронд болгон тогтоож, долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас цахимаар ажиллуулахаар зохицуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
Хэсгийн дундаж хувь:					
4. ГБХНХ-ын албан даалгавар					

1	2026.03.19 № 01 Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн сахилга, дэг журам, хариуцлагыг сахиулах тухай	Тус газрын Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Үндэсний хөтөлбөр, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын хэрэгжилтүүдийг нэмж тусган 3 бүлэг 18 заалттай төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр шинэчлэн баталсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээг зохион байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Албан хаагчдын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-ний талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалт, зөвлөмж, нөлөөллийн ажлыг тайлангийн хугацаанд 2 удаа газрын хэмжээний байцаагч, ажилтнуудыг хамруулан зохион байгуулж ажилласан. Зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар тухай бүр баримтжуулан газрын вэбсайт болон Facebook цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд тус газрын байцаагч, ажилтнуудтай холбоотой төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн талаарх иргэд даатгуулагч, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй байна.		
Хэсгийн дундаж хувь:				
Нийт дундаж хувь				

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН: ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ө.НАРМАНДАХ

ХЯНАСАН: ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ХАНДСҮРЭН

ТАНИЛЦСАН: ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АРИУНБОЛД

